


10 Ой мод

Энэ бүлэгт

Түүх: Ногоон бүс хөдөлгөөн	182
Ой ба эрүүл мэнд	183
Эмэгтэйчүүдийн ачаалал	186
Ой мод ба амьжиргаа	187
Түүх: Ой мод болон амьжиргаагаа хамгаалсан нь	188
Экологийн аялал жуулчлал	189
Ойгоос авч болох модноос бусад бүтээгдэхүүн	189
Түүх: Ойгоос эм хураан авсан нь	190
Ойг устгах	191
Ойн маргаан зөрчил	192
Дасгал: Нийгмийн драм	192
Ойг тогтвортой ашиглах	195
Дасгал: Хүн болгоны мэдлэгийг ашигла, хүн бүрийн хэрэгцээг тооц	197
Ойн менежментийн төлөвлөгөө хийх	198
Ойг хамгаалах нөхөрлөлүүд	199
Түүх: Амазоны ширэнгэн ойг хамгаалахын тулд хамтран ажилласан нь	199
Ойн нөөц	200
Түүх: Ойн аж ахуй хүн ба модыг тэтгэдэг	201
Ойжуулалт	202
Мод тарих нь дандаа хэрэгтэй юу?	202

Хуудас

Ой мод



Ой мод нь хүмүүст хоол унд, түлээ түлш, барилгын материал, зам, эм гэх мэт олон зүйлийг өгдөг юм. Ой мод нь хүний амьдралын орчныг тогтвортой эрүүл байлгахад үнэтэй үүрэг рольтой. Тэд агаарыг цэвэр байлгаж, усыг тунгалаг болгож, газрын хөрсийг эвдрэл, усны үерээс хамгаалж, хөрсийг шим тэжээлтэй болгон амьтан ургамалд гэр, сүүдэр нь болж, эргэн тойрныг үзэсгэлэнтэй сайхан байлгана. Ой мод орчныхоо амьдралыг үргэлжлүүлэн тэжээн тэтгэх боломжтой байлгахын тулд тэднийг хамгаалж, зүй зохистой ашиглах ёстой.

Ой модыг үйлдвэрлэлд хэрэглэхийг сонирхдог. Зарим үед түүний доорх газрыг ашиглах гэж тайрахыг эрмэлздэг. Гэвч тайрах амархан ч ургуулах хялбар биш. Ой модыг тайрдаг дэлхийн уул уурхайн компаниуд тайрахдаа тэднийг нөхөж ургаж гүйцэхийн аргагүй тайрч байна. Тэгж тайрах ажлаа тэд хүмүүсийн гар дээр цалин өгч байна гэж тайлбарладаг. Гэлээ ч газрыг ашиглах, газар дээрх нөөцийг ашиглах, тэр нөөцийг ирээдүйд зориулан хамгаалах ажлууд хоорондоо тэнцвэртэй байх ёстой. Тийм тэнцвэрийг хангах боломжтой юм.

Гэвч нөөцийг тэнцвэргүйгээр ашигласан газар бүрт удаан хугацаанд үргэлжлэх аюулын үндсийг тавьж байдаг. Их хэмжээний ойг устгаж цэвэрлэх нь ойн орчим олон үеэрээ амьдарч байсан хүмүүсийн амьдрал амьжиргааг сүйтгэнэ гэдгийг газар бүрт мэддэг юм.

Ногоон бүс хөдөлгөөн

Зүүн Африкийн Кени улсын Вангари Матай гэдэг эмэгтэй Кения уулыг үүлний цаана үргэлж нуугдаж байдаг ичимхий уул байсан гэж ярьж байна. Нутгийнхны хувьд, энэ уулнаас олон гол урсан орж ирдэг учир ариун дагшин уул хэмээн нэрлэгдэж иржээ. Гэтэл одоо Кения уул ичимхий байхаа больжээ. Уулыг бүрхдэг байсан үүлс алга болсон байна. Мөн уулыг далдалж байсан ой мод ч алга болжээ. Ой мод, үүл байхгүй болсноор бороо орохоо больж гол ус ширгэж эхэлжээ.

Вангари өсөж том болох явцдаа өөрийнх нь нутагт ойг хэрхэн тайрч байгааг хардаг байв. Ой тайрнаас болж хөрс хэрхэн элэгдэж, ус багасч, түлэх мод ч олдохгүй болсныг харж өсчээ. Вангари том болохдоо ой тайрнаас болсон ган гачиг ядуурлыг биеэрээ үзжээ. Ингээд Вангари мод тарьж эхэлсэн байна.

Вангари мод тарих ажилдаа эмэгтэйчүүдийг зохион байгуулалттай оруулжээ. Тэр эмэгтэйчүүдийг “Гэрийнхээ эргэн тойронд мод тарь” гэж ятгасан байна. Гэхдээ мод тарихдаа тэд бүслүүр шиг хэлбэрээр тарьж “Ногоон бүс” хэмээх хөдөлгөөнийг өрнүүлж эхлэв. “Ногоон бүс” хөдөлгөөний эмэгтэйчүүд нэг нэгэндээ мод тарихыг зааж, модгүйгээс болж хөрс шороо муудаж амьжиргаа хэрхэн муудаж байгааг хэлж байв. Тэд жимсний моднуудыг тариаланчдад авчирч өгөн жимсний моднуудаа хөрс шороо муудах газар болон налуу газарт тарьж эхэллээ.


Хот, тосгон аль алинд мод тарин ногоон бүс барьж, хатсан модоор түлээ хийх ажлыг эхэлснээр модыг дагаж айл гэрийн амьжиргаа сайжрах үндсийг бий болгож чадав. “Ногоон бүс” хөдөлгөөнийхөн ногооны талбайд борооны усыг цуглуулах жижиг усан сан барьж, хүмүүст эрүүл ойг сурталчилан семинар зөвөлгөөн хийх болжээ. Орон нутгийнхаа байгаль орчныг хамгаалахад үүрэг хариуцлага хүлээн ажилласнаар “Ногоон бүс” хөдөлгөөнийхөн засгийн газрын дэмжлэг шаардлагатай юм байна гэдгийг ойлгож, засгийн газрын дэмжлэгийг авах, Кенийн бүх хүмүүст туслахаар шийдлээ.

Мод тарих хөдөлгөөн нь Кени орон даяар энх тайван ардчиллын хөдөлгөөн болон өрнөв. Орон нутгийн иргэдийн дотор хэрүүл тэмцэл өрнөхөд “Ногоон бүс” хөдөлгөөнийхөн тэднийг уулзуулж, яриа хэлэлцээр хийхийн тул “Эвлэрлийн мод” тарих ажил өрнүүлдэг байлаа. Мод тарьдаг эмэгтэй гэдгээрээ алдаршсан Вангари үндэсний баатар болжээ. Гэвч түүнд олон бэрхшээл тулгарч байлаа. Бусдын төлөө хамаг амьдралаа зориулж байгаа хүчтэй эмэгтэйтэй амьдрахад хэцүү байсан учир нөхөр нь түүнийг орхин явжээ. Мөн тэрбээр ядуучуудыг зохион байгуулж, тэмцэл явуулж байсан учир засгийн газар түүнийг баривчилжээ. Гэвч түүний эр зоригийн хүчээр бүх Кеничүүдийн “Ногоон бүс” хөдөлгөөн олон сая мод тарьж чаджээ. 2004 онд Вангари Матай дэлхийн хамгийн нэр хүндтэй шагнал болох Нобелийн шагнал авсан юм. Энэ шагналыг түүнд энх тайван, тогтвортой хөгжил, эмэгтэйчүүдийн эрхийг сурталчилсных нь төлөө олгосон юм. Гэвч бүх юм мод тарих гэдэг ажлаас л эхэлсэн байлаа.



Ой ба эрүүл мэнд

Ой мод дэлхийн өнцөг булан бүрт хүний эрүүл мэндийг хамгаалж байдаг. Ой модноос хол амьдарч байгаа хүмүүст хүртэл ой модны ач тус хүрч байдаг ба ой мод алга болж, гэмтэж устахад түүнээс хол байгаа хүмүүс ч бас хохирч байдаг. Ой модыг сүйтгэхэд нийт орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн байдал аюулд орж, ой модоор дамжиж хүний эрүүл мэндийг хамгаалдаг зүйлс үгүйлэгддэг.



Ой мод нь орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, амьжиргаанд маш олон талаар тустай

Ой мод ба ус


Зарим хүмүүс ой модыг бороо татаж усыг газар доор хадгалдаг зүйлс гэдэгт итгэдэг. Зарим хүмүүс ой мод хэтэрхий их ус хэрэглэдэг гэж боддог. Ой модонд хэрэглэх усыг газар тариаланд хэрэглэвэл дээр гэж боддог. Ямар модыг хаана тарьснаас хамаараад эдгээр итгэл үнэмшил үнэн байх магадлалтай.

Модны газрын гүний үндэс нь усыг шүүж өгдөг. Химийн хортой бодис, хүнд метал болон химийн хортой бохирдлууд нь газрын хөрсний болон гүний усанд орсон бол ой мод түүнийг шүүж цэвэршүүлэх чадвартай. Модны үндсээр шүүгдсэн цэвэр ус нь худаг, гол горхи, нуур руу орж, бидний амьдарч буй усны ай савыг эрүүл усаар хангадаг.

Усны эх сурвалжийг хамгаалах ой модгүйгээр ундны ус болон угаалгын ус маань хамгаалалт муутай болно. Ийм учраас усны ойролцоо болон орон нутгийн оршин суугчдын ойролцоо байгаа моднуудыг тайрахгүй байх нь ашигтай бөгөөд тэдний тусламжтайгаар ус маань цэвэр тунгалаг, элбэг дэлбэг байдаг.


Гэхдээ зарим тохиолдолд, орон нутагт байдаггүй байсан хурдан ургадаг моднууд /208-р хуудаснаас үз/ нутгийн усны эх сурвалжийг хэрэглэж дуусдаг. Газар нутгаа болон усны эх сурвалжаа хамгаалахыг хүссэн хүмүүс ямар мод тарихаа нарийн тооцоотойгоор гаргах ёстой байдаг юм. Яагаад гэвэл, ямар мод тарьснаас хамаарч усны нөөцийн асуудал шийдэгдэнэ.

Ой мод ба цаг агаар



Ой мод нь цаг агаар, уур амьсгалд хүчтэй нөлөө үзүүлнэ. Ой мод нь цаг агаарыг хэтэрхий халуун, хэтэрхий хүйтэн, хэтэрхий хуурай байхаас хамгаалдаг. Моднууд нь орон гэр болон тариалангийн талбайг хүчтэй салхи, халуун нар, хүчтэй аадар борооноос хамгаална.

Том хэмжээнд авч үзвэл ой мод нь дэлхийн дулаарлаас биднийг хамгаалж, хортой агаарын бохирдлыг шингээн авч байдаг /39-р хуудсыг үз/. Ингэснээр ой мод дэлхийн цаг уурыг нэлэнхүйд нь урин зөөлөн болгоход тусална. Томоохон хэмжээний ой модыг устгаж үгүй болгосноор байгалийн гамшиг, ган гачиг, дулаан агаарын гэнэтийн урсгал, далайн шуургыг нэмэгдүүлдэг.



Ой модыг нь устгасан газарт цаг агаар хатуу ширүүн болно



Ой мод нь хөрсний элэгдлээс хамгаалж, үерийг багасгана


Хөрсөн дээр унасан навчис нь газрыг сүүдэрт байлган, ургамал амьтныг ургаж амьдрах таатай боломжоор хангана. Мөн ой мод газрын хөрсийг үндсээрээ бэхжүүлж батжуулснаар хөрсний элэгдлээс хамгаалж үерийг багасгадаг. Модны үндэс борооны усыг удаашруулж, түүнийг газар дээгүүр тарж урсахаас урьдчилан сэргийлж, усыг хөрс рүү шингэж ороход нь тусална.

Ой модыг устгахад газрын хөрс нь гол горхийг даган урсаж элэгдэнэ. Хүчтэй аадар бороо ороход газар усыг шингээн авч чадахгүй болж, борооны ус урсан алга болно. Ингэснээр борооны ус газар дээгүүр илүү хурдан урсаж үер үүсгэдэг. Байгалийн усны урсгалыг усны ай савын хүрээнд хамгаалж үлдэхийн тулд модыг ургаагаар нь үлдээж, ой модыг хамгаалах нь бүхнээс чухал байдаг юм. /Ой модгүй газарт бороо ямар аюул учруулдгийг 295-р хуудаснаас үз/

Ой дахь олон төрөлт амьдрал ба эрүүл мэнд

Ой модон доторх амьдралын хэлхээ холбоог хялбархан ажиглаж болно /33-р хуудсыг үз/. Эрүүл ойд олон янзын ургамал, амьтан байдаг. Энэхүү амьдралын олон янзын нийлбэр нь хүмүүсийн эрүүл мэндийг олон замаар хамгаалж байдаг. Модонд амьдардаг зөгий болон бусад шавжнууд үр тариа, модонд тоос хүртээж тэднийг цэцэглүүлж үр жимстэй болгодог. Шар зөгий болон шоргоолжнууд ургацыг сүйтгэдэг шавжийг иддэг. Сарьсан багваахай болон шувуунууд өвчин тараагч шумуулуудаар хооллоно. Ойн бусад амьтад ялаа, хэдгэнэ, харх хулгана, хачигаар хооллож өвчин тараахаас урьдчилан сэргийлэх ба тэднийг агнах нь эрүүл мэндэд хортой байдаг.

Хүний оршин суудаг тосгон суурингуудыг ойд ойрхон байлгаж, ойг хэтэрхий их ашиглах нь ойн амьдралыг ядууруулж амьдралын олон төрлийг өөрчилдөг. Амьтад хүнээс зугтан ойн гүн рүү нуугдаж, ойн амьдралын нэр төрөл цөөрснөөр ойд амьтны болон ургамлын өвчин тархах нь элбэгшдэг. Ойд янз бүрийн ургамал амьтан байлгах нь хүний эрүүл мэндийг хамгаалахад ашигтай.



Ой, хоол хүнс, түлш ба эм

Ойд маш олон төрлийн жимс, самар, ургамлын үр, үндэс, шавж, амьгад байдаг ба тэд хүний хоол хүнс, эм болж ашиглагддаг. Ойг буруу ашиглаж үржил шимгүй болговол үүнээс өвчин, тэжээлийн дутагдал бий болдог. Ойн нөөцөөс хамаарч амьдардаг хүмүүс ойн нөөц дуусангуут амьжиргаагаа дээшлүүлэх өөр арга хайх нь ажиглагддаг. Ойн эмийн ургамлууд алга болсноор хүмүүсийн ойн тухай мэдлэг ч ойн баялагтай хамт алга болдог. Ийм учраас ой мод, ойн баялгийг алдах нь уламжилж ирсэн чухал мэдлэг чадварыг давхар алдагдуулж байдаг.

Амьдралын нөөц ховордсон газруудад хүмүүс ойн үлдсэн нөөц болох модыг тайрч унагаан ойн үржил шимтэй газар дээр тариа ногоо тарихаар шийддэг. Ой модыг тайрч байгаа тариаланч хүртэл цэвэрлэж байгаа газартаа зарим модыг үлдээх нь чухал юм. Тариалангийн талбай, ойн талбайн өрсөлдөөний үеэр хангалттай хэмжээний модыг тайрахгүй үлдээх нь чухал юм. /Ой мод ба газар тариалангийн тухай 308-р хуудаснаас үзнэ үү/

Эмэгтэйчүүдийн ачаалал

Ойгоос мод түүх ажлыг ихэвчлэн хүүхэд, эмэгтэйчүүд хийдэг. Энэхүү ажлыг олон жилийн турш хийснээр эрүүл мэндэд янз бүрийн бэрхшээл үүсэх боломжтой. Ой мод багасах тусам хүмүүс илүү хол газраас модоо цуглуулах хэрэгтэй болно. Энэ нь хүмүүсийн хийх ажлыг нэмэгдүүлж өөрийгөө хөгжүүлэх цагийг багасгана. Түлээнд явж байгаа эмэгтэйчүүд, хүүхдүүд ойд очих замдаа хүчирхийлэлд өртөх боломжтой. Ийм учраас зарим газруудад эмэгтэйчүүд, хүүхдүүд өдрийн цагаар олноороо явж мод цуглуулдаг. Түлш болгон ашиглахад тохиромжтой моднуудыг гэрийнхээ ойролцоо олноор нь тарьж, арчилж ургуулах нь цаашдаа аюулгүй бөгөөд эрүүл байхад тустай.



Хол газар хүнд ачааг өргөж явах нь толгой өвдөх, нуруу өвдөх өвчин үүсгэдэг. Ялангуяа хүүхдийн нуруу хурдан гэмтдэг.

Бидний түмдэг ой мод тэр чигээрээ алга болсон учир бид юугаараа хоол хийх билээ.



Ой мод ба амьжиргаа

Ой мод нь амьжиргааны чухал эх үүсвэр юм. Засгийн газрууд болон олон улсын байгууллагууд ой мод их хэмжээгээр багасч байгаа нь ядуурал ихэссэнтэй холбоотой гэж тайлбарладаг. Хүмүүс хоол хүнс, ажил гэх суурь хэрэгцээгээ залгуулах орлогогүйгээс болж өдөр тутмын амьжиргаагаа сайжруулахын тулд ой мод руу дайрдаг. Зарим хүн тариалангийн талбайтай болохын тулд ой мод руу дайрахаас өөр аргагүй болдог. Энэ бүхэн ядуу хүмүүсийн ой сүйтгэхэд оролцдог шалтгаан юм. Гэхдээ ойг асар ихээр нь устгаж газрын хөрсийг эргүүлэн уул уурхай явуулдаг, газрын тос олборлодог том компаниудын ой мод сүйтгэж байгааг хүмүүс тэр болгон шүүмжилдэггүй.

Хүмүүсийн өдөр тутмын хэрэгцээг хангах бололцоо байвал хүмүүс байгаль орчин болон амьдралдаа илүү ихийг хийж чаддаг. Ойд амьдардаг, ойгоосоо амьжиргаагаа залгуулдаг олон хүмүүс ойд аюул учруулахгүйгээр ойгоос ашиг олох аргыг санаачилдаг. Ихэвчлэн ойг их хэмжээгээр устгах хэрэгцээ том үйлдвэрүүдийн сонирхол, ядуурал гэсэн хоёр үндсэн шалтгаантай байдаг.



Ойг устгах нь ядууралд хүргэдэг. Ядуурал нь ойг нэмж устгахад нөлөөлдөг.

Ойд тариалалт хийх

Ой модон дунд амьдардаг олон тариаланчид ойн тодорхой хэсгийг цэвэрлэж, эргэн тойрны ойг хөндөлгүй үлдээж тариагаа тарьдаг. Тэд ойн талбайг зэрлэг өвсөөр дүүртэл нь тариалдаг. Дараа нь тэд зэрлэг өвсгүй шинэ талбайг дахин гаргаж аваад шинэ талбайд тариалдаг. Энэ хооронд хуучин цэвэрлэсэн зэрлэг өвстэй талбайд мод тарьж шинээр ой ургуулдаг. Үүнийг зарим үед нүүдлийн тариалан гэж нэрлэдэг. Нүүдлийн тариалангийн аргыг олон мянган жилийн турш хэрэглэж ирсэн юм.

Гэвч хүн амын тоо нь өсөж шинэ суурин газрууд нэмэгдсэн тул газар тариалан эрхлэх талбай багасчээ. Түүнчлэн шинээр ойн талбай ч байхгүй болжээ. Ойн нүүдлийн тариалан нь тариаланчиддаа ч, ой модондоо ч тогтвортой удаан үргэлжлэх бололцоогүй болжээ. Ойн газарт тариа тарьж байгаа тариачид тогтвортой газар тариалангийн аргыг хэрэглэснээр нэг газраа удаан тариалалт хийж, илүү сайн ургац хураах боломжтой болж байна. /15- р бүлгийг үз/

Ой мод болон амьжиргаагаа хамгаалсан нь

Энэтхэгийн Андра Прадешийн ой модонд тосгоны оршин суугчид ойн хэсгийг цэвэрлэж тариа тарьдаг ажээ. Газар тариалангаас авах ургац багатай улиралд ихэнх хүмүүсийн амьдрал ойд ургадаг ургамлаас хамаардаг байна. Тосгоны зарим хүмүүс мод огтлон түлээ мод худалдаж, зарим нь модоор багаж тоног төхөөрөмж хийж зардаг ажээ.

Ой модноос ямар мод авах талаар зөвшөөрөл өгдөг газрыг орон нутгийн ойн хороо гэж нэрлэжээ. Ойн хорооныхон ой дотор тодорхой хэсэгт нь модыг хэтэрхий их огтолсон байвал мод огтлох хэмжээг бууруулж, ямар мод огтолж болохгүй вэ гэдгийг гаргаж, ямар хэмжээтэй мод огтлох журмыг гаргажээ. Шинэ журам маш хатуу бөгөөд олон хүмүүсийн амьжиргаа дордох магадлалтай байлаа. Модоор гар урлал хийдэг, мод зарж амьдардаг хүмүүс орлогогүй болов. Тариа ногоо тарьж чадахгүй үед эдгээр хүмүүс хамгийн түрүүнд ядуурчээ. Ойн хорооны гишүүд ч өөрсдөө ингэж амьжиргаа нь муудаж байгаа иргэдийн нэг хэсэг бөгөөд тэд орон нутгийн иргэдээ өлсгөхийг хүсэхгүй байсан ч ойн журмаа мөрдүүлсээр байв.

Олон уулзалт болсны дараа нэгэн шийдвэрт тэд хүрчээ. Ойн шинэ дүрмийг өөрчлөхийн оронд ойн хорооныхон тариалангийн талбайг өөрчилж, тахир муруй хэв гарган усны урсгалыг удаашруулж, газрын хөрсийг элэгдэлээс хамгаалахад туслахаар болжээ. Ингэснээр газрын хөрс баялаг болж, үр тарианд илүү их усыг хангаж тариалалт илүү ашигтай болсон ба ой модоо устгах аюулд хүрээд байсан хүн бүрт хангалттай хоол хүнсний ургамлыг тариалах бололцоотой болгожээ.

Экологийн аялал жуулчлал

Экологийн аялал жуулчлал гэдэг нь аливаа газар нутгийн үзэсгэлэнт байгалийг үзэхээр ирсэн хүмүүсээс орлого олох нэг арга юм. Аялах жуулчид орон нутгаар аялахдаа тэдний байгаль, амьтан болон амьдрах орчинг үзэхээр ирдэг. Зарим байгалийн аяллын төслүүд хүмүүст зөвхөн унаган байгаль үзүүлэх хүсэлтэй байдаг. Зарим нь орон нутгийн хүмүүстэй хамт амьдарч, тэдэнтэй хамт байгаль орчныг хамгаалах хүсэлтэй байдаг. Бас зарим төслүүд байгаль орчныг хамгаалах ажиллагааг идэвхтэй байлгах байгаль орчны аялал хийдэг.

Ойд амьдардаг иргэд аялал жуулчлалын аргаар мөнгө олох таатай нөхцөл нь байгалийн аялал жуулчлал юм. Гэхдээ байгалийн аялал жуулчлалыг эхлүүлэхэд тодорхой хөрөнгө хэрэгтэй бөгөөд маш нарийн төлөвлөгөө хэрэгтэй байдаг. Аялагч нарт хоол, орон сууц, тайлбарлагч, соёлын ялгааг тайлбарлаж өгөх мэдлэгтэй хүмүүс хэрэгтэй байдаг. Оролцогчид янз бүрийн туслалцаа авах болон эрүүл мэндийн туслалцаа авах хэрэгтэй болж болно. Жуулчдыг татахын тулд мэндчилгээ интернетээр илгээх, мөн сурталчилгааны товхимол хийх хэрэгтэй болно.

Байгалийн аяллаас олж байгаа мөнгийг орон нутагтаа үлдээж, жуулчлалаас авч байгаа мөнгийг зөвхөн гаднын агентлагуудад алдчихгүйн тулд байгалийн аялал жуулчлалыг сайн зохион байгуулах хэрэгтэй. Сайн зохион байгуулагдсан аялал жуулчлал нь тодорхой хязгаарыг тогтоох бөгөөд ингэснээрээ байгальд учрах гэмтэл бохирдлыг багасгаж, байгалийг цэвэр байлгадаг юм.

Ойгоос авч болох модноос бусад бүтээгдэхүүн

Модноос бусад бүтээгдэхүүн гэдэг нь ойг гэмтээхгүйгээр ойгоос авч болох, зарж борлуулж болох ямар ч зүйлийг хэлж болно. Үүнд самар, жимс, мөөг, эмийн ургамал болон бусад ургамал орно. Мод гуалингаас бусад ойн бүтээгдэхүүнийг зарж борлуулдаг орон нутгийнхан дараах дүрмийг баримталж амжилтад хүрдэг:

- Хэн ургац хураах, бүтээгдэхүүнийг зарж борлуулах талаар тодорхой дүрэм гаргана. Мөн тогтвортой аргаар үр жимсийг хураахдаа ямар дүрэм баримтлахыг заана. Аливаа бүтээгдэхүүний борлуулалт амжилттай байх үед ургац хураалт хэмжээнээсээ илүү явагдах аюул тулгардаг. Энэ үед тухайн бүтээгдэхүүнийг үргэлжлүүлэн ургаж, өсөж үржихэд нь хангалттай хэмжээг үлдээж ургац авна.
- Тодорхой бүтээгдэхүүнд зориулан зах зээлийг олж хөгжүүлнэ. Хэрэв худалдах зах зээл байхгүй бол ойгоос бүтээгдэхүүн хураасан ч зарж борлуулж чадахгүй болно.



Ойгоос эм хураан авсан нь



Энэтхэгийн Бенгалын эргийн ойролцоо олон хүмүүс өвчин туссан үедээ уламжлалт аргаар эмчилдэг эмчид очдог. Уламжлалт эмнэлгийнхэн ойгоос түүсэн ургамлаар эмээ бэлтгэдэг. Нэгэн удаа нэгэн төрийн бус байгууллагын хүмүүс тосгонд ирж хүмүүсийг эмийн ургамал цуглуулж хотод борлуулахад нь туслахаар болжээ. Эмийн ургамлыг хотод зарахад нь тусалснаар тэрхүү төрийн бус байгууллага орон нутгийн иргэдийг ойгоо тайрахгүйгээр мөнгө олох аргыг заажээ.

Мөнгө олох шинэ аргатай болсондоо тосгоныхон маш баяртай байсан ба хүмүүс эмийн ургамал цуглуулахаар ойд очдог болжээ. Гэвч тэдгээр хүмүүс ургамлыг гэмтээхгүйгээр яаж түүхийг уламжлалт эмнэлгийн эмч нараас асуусангүй. Бас хичнээн хэмжээтэйгээр түүхийг хэнээс ч асуусангүй. Эмийн ургамал түүх гэж хүмүүс яарсандаа эмийн ургамал ургадаг модыг хугалж гэмтээж эхэлжээ. Жишээлбэл, модны эргэн тойрныг ухаж цөөхөн хэмжээний үндэс авахын оронд тэд бүхэл бүтэн модыг унагаажээ. Богинохон хугацааны дотор ойгоос эмийн ургамлууд бараг устаж үгүй болжээ. Ингэснээр уламжлалт эмнэлгийн эмч нар эмчилгээнд хэрэглэх ургамалгүй болсон байна. Энэ үед тосгоныхон өвчин туссан үедээ эмийн сангаас гадаад үйлдвэрлэсэн өндөр үнэтэй эм авах болжээ. Эцэст нь ойгоос эмийн ургамлыг буруу түүснээс болж хүмүүсийн эрүүл мэнд муудаж, ирээдүйдээ хор хохирол учруулсан байна.

Ойг устгах

Ихэнхи ойг модны үйлдвэрүүд, мод бэлтгэх компаниуд устгадаг. Тэд модыг эргэн нөхөгдөхгүй байдлаар ашиглаж ашиг орлого олдог юм. Нэг ойг устгаж дуусаад том компаниуд нөгөө ойг устгахаар нүүдэг. Харин устгагдсан ойн хажууд амьдардаг хүмүүс компанийг дагаад нүүхгүй учраас ойгүй болсон газраа үлддэг юм. Ойгүй газар амьдардаг хүмүүс ч гэсэн маш их модон бүтээгдэхүүн хэрэглэдэг. Жишээлбэл ном, сонин, барилгын материал, тарианы үр, далдуу модны тос зэрэг ойгоос гаргаж авсан, ойд ургасан ургамлыг идэж төлжсөн олон зүйлсийг хүмүүс хэрэглэдэг. Өдөр тутмынхаа хэрэглээнээс ой модтой холбоотой бүтээгдэхүүнийг хэрхэн хасч цөөлөх талаар хүмүүс бараг бодож чаддаггүй юм.

Ой хэрхэн багасч устгагдаж байна вэ?

Хэрэв ой модыг одоогийн байдлаар устгасан хэвээр байх юм бол, хэрэв ой модыг буцааж ургуулж, үржүүлж чадахгүй бол бид удахгүй ой модгүй болно. Ойг их хэмжээгээр устгаж гэмтээдэг чиглэлүүдийг дурьдвал:

- **Мод бэлтгэлийн ажил** /тодорхой газруудын ой моднуудыг юу ч үгүй тайрах/, энэ хэлбэрийн мод огтлох бизнес нь газрын хөрсийг эвдэлж, элэгдүүлж, зэрлэг ан амьтны амьдралыг устгаж, усан замыг шавар бохироор дүүргэдэг.
- **Эрчимтэй мал аж ахуйн том фермүүд**, том үхрийн аж ахуй, нэг төрлийн модыг их хэмжээгээр тарихын тулд ойн талбайг цэвэрлэдэг бизнесийнхэн.
- **Усны эргийн дагуух ойг тайрч** цэвэрлэн тэр газар хавч хясаа үржүүлэх, загас үржүүлэх фермүүд. Эдгээр фермүүд нь жижиг загасны аж ахуйг өрсөлдөөнөөр шахаж, усыг бохирдуулж, өвчин ядуурал болон хоол тэжээлийн дутагдлыг нэмэгдүүлдэг.
- **Цаасны үйлдвэрүүд**: цаасны үйлдвэрүүд нь хортой хаягдлыг гаргаж газар, ус, агаарыг бохирдуулдаг.
- **Уул уурхай, газрын тос болон хий олборлох компаниуд** ой модыг тайрч, их хэмжээний хортой хаягдал үлдээх ба ус, газар, агаарыг бохирдуулдаг.
- **Том усан сан барих төслүүд**:

эдгээр төслүүд нь ой модтой том газар нутгийг үерт автуулдаг.

Усан сан барих газрын хүмүүс нүүхээс өөр аргагүй болдог.

Шинэ газарт нүүгээд шинэ байшин барихын тулд хүмүүс их хэмжээний модыг тайрч огтлох хэрэгтэй болдог.



Модыг худалдан авч зарж борлуулах явцад засгийн газар болон бизнесийн корпорациуд ой тайрснаас үүдэж хүний эрүүл мэнд амьжиргаа хэрхэн дордож байгааг тэр болгон тооцдоггүй.

Ойн маргаан зөрчил

Ойн нөөц хязгаарлагдмал учраас ойг янз бүрээр ашиглахыг хүссэн хүмүүсийн хооронд зөрчил үүсдэг. Энэ зөрчил ихэвчлэн ойгоос хамаарч амьдардаг орон нутгийнхны дунд болно. Мөн гаднаас ирж ойг ашиглах гэсэн компани ба иргэдийн хооронд маргаан болно.

Жүжигчилсэн дасгал

Социодрам буюу нийгмийн драм нь театрыг ашиглан гарч болох зөрчил болон тэдгээр зөрчлийн шалтгааныг бодож үзэж шүүн тунгаахад тусална. Социодрам нь хүмүүст асуудлыг шийдэж өөр талаас харахад тусална. /23-р хуудсыг үз/

1 Таван хүнээс бүрдсэн бүлгүүдийг зохион байгуулж, бүлгүүдийн дунд ойн зөрчил үүсэж болохуйц нөхцөл, жишээнүүдийг өг. Хүмүүст итгэж болохуйц жишээг гаргах ба ингэхдээ орон нутгийн хүмүүсээ эвгүй байдалд оруулахгүйн тулд холын жишээ авбал зүгээр. Хүмүүс дүрдээ тоглохын тулд өмссөн хувцастайгаа биш энгийн хийцтэй тайзны хувцас өмсвөл зүгээр.

2 Бүлэг бүрийг 15-20 минутад багтаж 5 минутын жүжигчилсэн тоглолт бэлтгэж даалгавар өг. Хүн болгоныг ямар нэгэн дүрд тогло гэж шаардлага тавь. Дараа нь бүлэг бүр өөрсдийн бэлтгэсэн жүжгийг бусад бүлгүүдийн өмнө тоглоно. Жүжиг дууссаны дараа бүх сэдвүүдээр ярилцлага явуулж, орон нутгийн иргэдийн дунд зөрчил үүсгэж байгаа асуудлыг яаж шийдэхийг хэлэлцэнэ.



3 **Танд ямар санагдав?** Танд юу бодогдов? Тоглолт дууссаны дараа тоглолтод оролцсон бүх хүмүүсээс ингэж асуу. Бас түүнийг үзсэн хүмүүсээс ойн зөрчлийн талаар юу гэж бодож байгааг нь асуу.



Жүжигчилсэн тоглолтыг удирдаж байгаа удирдагч тухайн орон нутагт байгаа зөрчлийг мэдэж байх ёстой. Мөн тухайн зөрчлийг иргэд өөр өөрөөр хүлээн авч байгаа гэдгийг мэдэж байх ёстой. Жүжигчилсэн тоглолт, түүний тайлбар ярилцлагын үеэр хүмүүсийг үргээж ичээлгүйгээр тайван хэлэлцээр өрнүүлэх чадвартай бай.

Нийгмийн драм /үргэлжлэл/

Доорх ой модтой холбоотой нийгмийн драмын сэдвүүдээс сонго. Эсвэл өөрсдийн орон нутагт тохиолдож байгаа болон тохиолдож байсан зөрчлүүдээс сонгож болно.

1-р тохиолдол: Дүрүүд: үхэртэй малчин эр, эмийн ургамал цуглуулагч, орон нутгийн хурлын оролцогч нар.

Орон нутгаасаа олон жил хол байсан нэгэн эр 10 үхэртэй эргэж ирэн нутгийн нийтийн эзэмшлийн ойд үхрээ бэлчээж эхэлнэ. Эмийн ургамал цуглуулахаар ойд гарсан хүмүүс эмийн ургамлын ихэнхийг үхэр идсэн байгааг олж харна. Тэд орон нутгийн нийтийн хурал зарлаж энэ асуудлыг хэлэлцүүлэхээр иржээ. Үхрийн эзэн залуу үхрээ хаа дуртай газраа бэлчээх эрхтэй гэж маргалдана. Орон нутгийн иргэд эсэргүүцнэ. Цаашид юу болох бол?



2-р тохиолдол: Дүрүүд: мод тайрдаг залуу эр, засгийн газрын ажилтан, түлээ цуглуулдаг эмэгтэй. Нийтийн эзэмшлийн газар дээр хэдэн залуу эрчүүд зөвшөөрөлгүйгээр мод тайрч орон нутгийн засаг захиргааны нэгэн ажилтанд худалдана. Орон нутгийн засаг захиргааны ажилтан авсан модоо ачааны машинд ачуулан явуулдаг. Ихэвчлэн түлээний мод цуглуулдаг газар руугаа очсон эмэгтэй залуу эрийг мод тайрч байхыг олж харсан байна. Залуучуудын нэг нь түүний хүү байжээ. Эмэгтэй орон нутагт эргэн ирж бусад залуучуудын ээжүүдэд бидний хүүхдүүд мод тайраад байна гэж хэлэв. Маргааш нь эмэгтэйчүүд хамтдаа ууланд гарч залуучуудыг мод тайрахыг нь болиулав. Эхний эмэгтэйн хүү "Би мод тайрч мөнгө олоод нялх охиныхоо эмчилгээнд зарцуулах гэсэн юм" гэж охиныхоо эмээд хэлнэ. Дараа нь юу болох бол?



3-р тохиолдол: Дүрүүд: үхэр тэрэгтэй сүх барьсан орон нутгийн иргэд, засгийн газрын ажилтан, цахилгаан хөрөөтэй ачааны машинтай, мөн тосгоны зөвлөлийн албаны хүмүүс. Олон үеийн турш хүмүүс модыг сүхээр цавчин унагаж үхэр тэргэндээ ачиж хэрэглэж байжээ. Харин энэ удаад орон нутгийн засаг захиргааны ажилтан цахилгаан хөрөөтэй ирж модыг олноор нь тайрах боллоо. Ингэхдээ тэр, мод бол улсын өмч гэж хэлэх болжээ. Нэгэн удаа засаг захиргааны ажилтан залуу булдозертой хүнд тоног төхөөрөмжтэй ирлээ. Тэд ойгоос хамгийн том моднуудыг тайрч зам барихад ашиглана гэж хэллээ. Орон нутгийн хэдэн залуучууд ойд очиж түүнтэй маргалдахаар явлаа. Дараа нь юу болох бол?



Нийгмийн драм /үргэлжлэл/

4-р тохиолдол:

Нийгмийн драмыг хэлэлц. Жүжигчдийг нийгмийн драмд тоглоод явах бүртээ хувцсаа нэг газраа хураагаад буцаж ирэхдээ ашигла гэж зөвлө. Дараа нь нийт бүлгийн хэмжээнд туслахын тулд хэд хэдэн асуулт асуу

- Нийгмийн драмд ямар асуудал гарсныг хэл.
- Маргаан үүсгэсэн үйлдлүүд юу байв гэдгийг тогтоо.
- Маргааны уг шалтгаан болж буй янз бүрийн хэрэгцээг тогтоо.
- Маргааныг хэтийн бодолтой ухаалгаар шийдвэрлэж болох арга замуудыг санал болго.

Энэхүү процессийг нийгмийн драм бүрийн дараа давтан хий. Нийгмийн драмыг хөтлөгч нь том цаасан дээр юм уу, самбар дээр хүмүүсээс гарч байгаа чухал санаануудыг бичиж болно.

А: Зөрчил ойнаас үүсэв?

Х: Нэг залуу чхэр өсгөхийг хүссэн гэхдээ олд гэмтээсэн

А: Яагаад тэр залуу чхрээ ойд бэлмээж болно гэж бодсон бэ?

Х: Ойг хэн хэрхэн ашиглах, ямар зорилгоор ашиглах талаар гэрээ хэлэлцээр байхгүй байсан.

А: Ойд үндсэн гэмтэл орон нутагт яаж нөлөөлөв?

Х: Эм, эмийн ургамал байхгүй болсон.

А: Ямар хэрэгцээндээс үүдэж зөрчил үүсэв?

Х: Ойгоос бүтээгдэхүүн авах болон чхрээ бэлмээж хэрэгцээндээ үүсчээ

А: Энэ хоёр хэрэгцээг хоёуланг нь хангаж чадахуйн арга зам бий юу?

Х: Чхэр малыг нийтийн хэрэгцээтэй

ургамал ургадаггүй газарт бэлмээж болно.

Х: Чхрийн эзэн бэлмээрээ хашаалж болно.

Х: Чхрийн эзэн ойн бүтээгдэхүүн


цуглуулах эрхээсээ татгалзаж болно.

Ойн бүтээгдэхүүн цуглуулах эрхээсээ татгалзаж ойд чхрээ бэлмээж болно. Дараа нь тэр хэрэгтэй чхдээ ойн бүтээгдэхүүнийг худалдаж авч болно.

Хэрэв энэ ярилцлагын явцад хүмүүс ихэд маргалдаж байвал яриаг дуусгахдаа хүн болгоныг эвлэрүүлж чадах сэдэв буюу үйл явдлаар дуусгах хэрэгтэй. Жишээлбэл, хэлэлцүүлэг болгоны дараа хамтран дуу дуулдаг байх нь хүмүүсийг эвтэй найртайгаар ярилцлагаа өндөрлөхөд тусалдаг.



Хүмүүсийг жүжигт тоглосных нь дараа уг жүжигт өмссөн хувцсыг нь тайлуулж, гүрээс гаргах нь чухал. Иргэдийг жүжигт тоглосон гүрээр нь муу хүн гэж харал вий гэж болгоомжилж байх ёстой. Жүжгийн гүр болон жинхэнэ хүмүүсийг хооронд нь ялгаатай байгаа.




Ойг тогтвортой ашиглах

Ойг тогтвортой ашиглах менежмент гэдэг нь ойгоос өдөр тутмын хэрэгцээний зүйлсээ авч хэрэглэхийн зэрэгцээ ойг хамгаалах, ирээдүйдээ үлдээх гэсэн үг юм. Ойг хамгаалах тогтвортой аргууд нь газар бүрт ижил байдаггүй. Орон нутаг бүр ямар аргаар ойгоо хамгаалбал зохистой вэ гэдгээ олж тогтоох ёстой.

Ойг тогтвортой, хамгаалж ашиглах төлөвлөгөөг орон нутгаараа гаргаж шийдвэрлэх нь ойг тогтвортой ашиглахад хэрэгтэй. Ийм төлөвлөгөө гаргаснаар засгийн газар, үйлдвэрлэгч нараас ирэх аюул заналхийллийг эсэргүүцэхэд тусалдаг. Заримдаа бүтээгдэхүүнийг олон жилийн турш үргэлжлүүлэн тогтвортой нийлүүлж чадна гэдгийг нотолж чадах юм бол таны бүтээгдэхүүн үнэд хүрдэг. Гэхдээ ойн тогтвортой менежментийн хамгийн чухал ач холбогдол нь орон нутгийн хүмүүс хамтран ажиллаж ойгоо хамгаалахад тусалдаг юм. Ойг ашиглахын зэрэгцээгээр хамгаалж болдог доорх аргууд байна.


- **Ойн арчилгаа** /ойд гэрэлтүүлэх огтлол хийх/ Ой модны ургамал, бут модыг нарны гэрэлтэй байлгахын тулд ойд арчилгаа хийдэг.



Ойг арчилна гэдэг нь ойд байгаа зарим модыг тайрч модны хоорондын зайг хангалттай үлдээж, модыг бүдүүрч томроход нь тусална гэсэн үг юм.


- **Ойжуулах:** энэ нь ойд шинэ төрлийн мод ургамлыг хуучин хөгшин модны ойролцоо буюу эсвэл модгүй ойн цоорхойд тарина гэсэн үг.
- **Ойг нөхөн сэргээх:** энэ нь огтолсон мод бүрийн оронд шинэ мод, үрсэлгээг тарьж, тайрсан модны орчимд мод үлдээх арга юм.
- **Хяналттайгаар шатаах:** модны доор бут, шарилж их хэмжээгээр ургахаас урьдчилан сэргийлж хяналттай гал тавьдаг. Ийнхүү илүүдэж шавсан бутыг тэжээлийг нэмэгдүүлнэ. Хяналттай галыг маш болгоомжтой удирдаж унтраах ёстой. Эс тэгвэл гал хялбархан хяналтаас гарна.
- **Модыг түүвэрлэн огтлох:** залуу моднуудыг үлдээж, хөгшин модыг сонгож тайран ойгоос цөөхөн мод сонгож огтлохыг түүвэрлэн огтлолт гэнэ. Ингэхдээ үр жимсээ ид өгч байгаа, үржил сайтай, ойг нөхөн төлжүүлэх чадвар сайтай моднуудыг үлдээнэ.

Түүвэрлэн огтлолт хийх нь зориуд сайн модыг үлдээж, ойг өсч томрох боломжийг хангана.




- **Ойн дагалдах баялаг** модон бус бүтээгдэхүүнийг цуглуулж зарах: ойгоос мод авч зарахын оронд ойд ургадаг жимс, самар зэрэг бусад бүтээгдэхүүнийг авч зарах нь ой хамгаалах болон ойгоос орлого олох арга юм.
- **Ойд малаа бэлчээхгүй байсных нь төлөө малчдад төлбөр төлөх:** ойгоос мод авахгүй байж чадвал тариаланчдад төлбөр төлж шагнах зэрэг нь ойг эрүүл байлгаад зогсохгүй ойн маргаанаас урьдчилан сэргийлнэ.
- **Зэрлэг амьтдын амьдралын зурвасыг хамгаалах:** зэрлэг амьтдыг амьдрах, нүүхэд тохирсон ойн томоохон хэсгийг хөндөлгүй үлдээх, мөн нэг ойгоос нөгөө ой руу зэрлэг амьтад нүүж шилжихэд нь туслах, хөндөгдөөгүй талбай үлдээх нь зэрлэг амьтдыг хамгаална.
- **Ногоон талбайг байгуулах:** ихэнх модыг нь тайрч унагаасан, ой модыг нь бараг устгасан газруудад хөрс шороо, ус, агаар нь бохирдсон байдаг. Хот суурин болон орон нутгийн ойролцоох ийм газруудад мод шинээр тарьж ногоон талбай байгуулдаг.
- **Байгалийн нөхөн ургалтыг дэмжих:** хэтэрхий олон мод тайрсан газруудад мод тайрахыг таслан зогсоосноор мод байгалийн аргаар нөхөн сэргээгдэж эхэлдэг.

Мал амьтад нь ойн хөрсийг машинаас бага хэмжээгээр дагтаршуулна.



- **Ердийн хөсгөөр** /үхэр тэрэг зэрэг/ мод түлээ зөөлгөж чирүүлэх: энэ нь булдозер, трактораар мод зөөхөөс илүү хөрс, ой модыг хамгаалдаг.
- **Модны мөчир, холтос, үйс авах:** унасан модыг ачуулахын өмнө бусад мод ургамалд учрах аюулыг багасгахын тулд түүний мөчир холтоснуудыг цэвэрлэх хэрэгтэй. Холтос мөчрүүд ялзмагтай хөрс шороон дээр нэмэгдвэл хөрс шорооны чанар сайжирна.
- **Байгалийн аялал жуулчлал:** байгалийн аялал жуулчлал нь хүмүүст байгалийн гоо сайхныг үзүүлэхийн зэрэгцээ байгальд ямар ч хор хохирол учруулахгүйгээр ой модноос ашиг олоход тусалдаг.



Ой модыг олон янзаар ашиглахын зэрэгцээ ирээдүйдээ үлдээж болно.

Хүн болгоны мэдлэгийг ашигла, хүн бүрийн хэрэгцээг тооц

Энэхүү дасгал нь ойн нөөцийг хүн бүхэнд ашигтайгаар хэрхэн ашиглаж, хамгаалах талаар дадлага болно. Энэхүү дасгалыг 25 хүртэлх хүнтэйгээр ажиллаж болох бөгөөд хүмүүсийг гурван жижиг бүлэгт хуваана. Ойн талаар гаргасан шийдвэр хүн бүхэнд нөлөөлдөг бөгөөд энэ шийдвэрээс болж өөрт нь нөлөөлөх бүх хүнийг оролцуулах нь чухал.

Хугацаа: 3-6 цаг буюу /хэрэв газрын зургаа хадгалбал энэ дасгалыг богино цагаар хэд хэдэн удаа үргэлжлүүлж болно /
Материал: үзэг харандаа, тэмдэглэлийн дэвтрийн цаас, өөрийн оршин суугаа газрын зургийг зурсан гурван том цаас, наалддаг скоч. Газрын зургийг хүмүүст танигдах хэмжээнд бүдүүвчлэн зурсан байж болно.



- 1 Бүлэг бүхэнд нэг газрын зураг өг. Хүн бүрийг тэмдэглэлийн дэвтрийн цаасан дээр ойд ороод юу хийдгээ зур гэж хэл. /мод огтлох, мал маллах, жимс ургамал түүх, ан агнах зэрэг/
- 2 Бүлэг бүрийн хүн нэг бүр бүлэг дотроо өөрийн зурсан зургийг тайлбарлаж, өөрсдийн хийдэг ажил нь тэдний хувьд хэр зэрэг чухал болохыг ярина. Дараа нь нэгээс хоёр хүн том зурган дээр хүмүүсийн хийдэг ажлыг наах бөгөөд ингэхдээ ойн аль хэсэгт хэн юу хийж байгааг байрлуулна.
- 3 Бүлгүүдийг хамтад нь цуглуулан тэдгээрийн газрын зурагнуудыг тайлбарлуулж хэлэлцүүлнэ. Ойн зарим хэсэг бусдаасаа илүү их ашиглагдаж байна уу? Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхдүүд болон өндөр настнууд ойг өөр өөрөөр ашиглаж байна уу? Ойг хэрхэн ашиглаж байгаа талаар санаанд оромгүй гэнэтийн зүйлс байна уу?
- 4 Дасгалыг удирдагч ойн эрүүл мэндийн талаар хэлэлцүүлэг эхлүүлж дараах төрлийн асуултуудыг асууна. Ойгоос авч байгаа нөөц тань урьдын адил элбэг дэлбэг байна уу? Ойд байгаа шувуу, амьтан, ургамал цөөрсөн үү? Бүх модыг нь тайрч хаясан хэсэг газар ойд бий юу? Тэр газруудад одоо юу тохиолдох вэ?



- 5 Бүлэг бүрээс нэгээс хоёр хүн гарч бүлгийнхээ газрын зургийг өнгөөр ялгаж тэмдэглэнэ. Ингэхдээ ойн эрүүл хэсэг, муудсан хэсэг, ой алга болсон хэсгийг өөр өөр өнгөөр тэмдэглэнэ.

- 6 Ойн янз бүрийн хэсгүүдийн талаар бодож, ямар өөрчлөлт гаргахыг хүсч байгаагаа ярилц, тэдгээрийг газрын зурган дээр зурах буюу бичиж болно. Дараагийн хуудсан дээр энэхүү хэлэлцүүлгийг хэрхэн үргэлжлүүлэх талаар чиглүүлэх асуудлууд бий.



Ойн менежментийн төлөвлөгөө хийх

197- р хуудасны дасгалыг ажилласны дараа дараах асуудлуудын талаар бодож үз:


- Ойгоос бид ямар ашиг нөөцийг хүртдэг вэ? Ямар мод ургамал, амьтдыг бид ашигладаг вэ? Улирал бүрт хэр зэрэг ихийг бид хэрэглэдэг вэ? Эдгээр нөөц ховордсон буюу алга болсон ойн хэсгүүд хаана байна вэ?
- Ойг бид хэрхэн арчлах вэ? Орон нутгийнхан мод тарьж, тодорхой хэсгийг нь хамгаалж, ойг эрүүл байлгах талаар арга олж чадсан уу?
- Ойн зарим хэсгийг ашиглахгүйгээр хамгаалалтад авах ёстой юу?

Хамгаалалтад авсан ойг ашиглахгүй болсноор хэнд, хэний амьжиргаанд хортойгоор нөлөөлөх вэ?

- Ойн зарим хэсэгт тогтвортойгоор ашиглах аргуудыг хэрэглэх ёстой юу? Ойг тогтвортой ашиглаж арчлах талаар орон нутгийн иргэдэд ямар мэдлэг туршлага байгаа вэ?

Ойг тогтвортой ашиглах менежментийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд

- Бидэнд ямар ур чадвар хэрэгтэй вэ? Хэрэв бидэнд ур чадвар дутагдаж байгаа бол түүнийг олж чадах уу? Бид өөр байгууллагад хандах ёстой юу? Бидэнд мэдлэг туршлага зааж өгөх ямар байгууллагатай хүчтэй харилцаа тогтоох ёстой вэ?
- Бидний орон нутаг ойн төслүүдийн талаар шийдвэр гаргахад яаж нөлөөлж чадах вэ? Гаднын хүмүүс ирж ойг ашиглах үед орон нутгийн иргэдийн хүчтэй байр суурийг илэрхийлж ойг тогтвортой ашиглуулах бололцоотой. Бид ийм зохион байгуулалтад орж чадах уу?
- Бид бүтээгдэхүүнээ ямар зах зээл дээр гаргах вэ? Бүтээгдэхүүнийг орон нутагт худалдах нь хялбар бөгөөд үндэсний болон гадаадын зах зээл дээр гаргах нь илүү үнэтэй байдаг. Орон нутагт бүтээгдэхүүн худалдах үнэ бага ч гэсэн борлуулалтын зардал нь бас бага байдаг.
- Манай ойн бүтээгдэхүүний үнэ өртөг ямар байх вэ? Хэрэв бидний ойн бүтээгдэхүүн шударга үнэд хүрч чадахгүй бол шударга худалдааг дэмждэг байгууллагуудад хандаж болно.
- Шинэ төлөвлөгөө маань ямар өөрчлөлтийг авчирч чадах вэ? Шинэ менежментийн төлөвлөгөө маань зарим хүмүүст ой ашиглахыг нь хязгаарлах уу? Хязгаарласан бол орон нутгийн зүгээс тэдгээр хүмүүст хариуд нь юу өгч чадах вэ?



Ойг хамгаалах нөхөрлөлүүд

Ойгоос амьжиргаагаа залгуулдаг аль болох олон хүмүүсийг олон бүлэгт нэгтгэж, хүн бүхний хэрэгцээ шаардлагыг тооцон нөхөрлөл байгуулах нь тохиромжтой байдаг. Нөхөрлөлүүд өөрсдийнхөө эрхийг хамгаалахын тулд гаднын байгууллага, хүмүүстэй хамтран ажилладаг.

Амазоны ширэнгэн ойг хамгаалахын тулд хамтран ажилласан нь

Амазонын хүмүүс одоогийн амьдарч байгаа газартаа үргэлж амьдарч байсангүй. Кючуа омгийн хүмүүсийг Амазон голын ойролцоох унаган газартаа амьдарч байхад нь их хэмжээний нефть асарч тэд нүүхээс өөр аргагүй болсон юм.

Үйлдвэрийн аргаар эрчимжсэн газар тариалан хөгжүүлэх үед тэдний амьдардаг байсан ой ширэнгэ устаж, тосгоныхон уламжлалт аргаараа ан агнаж, загас барьж, ойгоос эмийн болон хоол хүнсний ургамал түүж амьдарч чадахаа больсон юм.

Тэд шинэ газартаа буусны дараа өөрсдийн эргэн тойрны газрыг хуучин заншлаараа ашиглахыг хүсч байлаа. Гэвч энэ нь тэдэнд өөрсдийнх нь боломжоос илүү их газар шаардлагатай гэсэн үг байв. Амазонын хүмүүс засгийн газраас тэдэнд газар олгохыг шаардаж, өвөг дээдсийнхээ адил амьдрахыг хүсч байна гэлээ. “Бид зүсэм талх шиг хэмжээтэй зүсэм газарт амьдарч чадахгүй” гэж хэлээд бид газар нутгаа буцааж авмаар байна ойдоо амьдармаар байна гэж шаарджээ. Засгийн газар тэдний шаардлагыг үл тоомсорлоход Амазоныхан олон улсын ой хамгаалах байгууллагад хандаж тусламж гуйжээ. Амазоныхан гадаадынхныг урьж уламжлалт ёсоороо амьдарвал яаж ойгоо хамгаалдаг баримтжуулах кино хийлгэжээ. Гадаадын хүмүүс Амазоныхны уламжлалт амьдралын зургийг аваад явжээ. Хэдэн жилийн дараа Амазоныхан 2000 га газар худалдаж авах мөнгө цуглуулжээ. Ийм их мөнгө олсон нь ойролцоо амьдардаг Шуар омгийнхонд сэжиг төрүүлсэн байна. Шуар омгийнхон Амазоныхны авсан газрын зарим хэсгийг өөрсдийн газар хэмээн зарлахад Амазонын хүмүүс алдаа гаргаснаа мэджээ.

Тэд гадаадын хүмүүстэй хэлхээ холбоотой болж чадсан хэрнээ хөршүүдтэйгээ хэлхээ холбоотой болж амжаагүйгээ ойлгожээ. Шуар омгийнхон маш их уурсаж газрыг хүчээр булаан авна хэмээн заналхийлэх болов. Олон уулзалт хийсний дараа Амазонын болон Шуар омгийнхон ой модыг хувааж ашиглахаар тохиролцов. Яагаад гэвэл Амазонын болон Шуар омгийнхон ойг хэрхэн зөв ашиглах талаар ижил ойлголттой байсан учир тэд хамтран эвсэл байгуулахад хялбар байжээ.

Тэд өөрсдийн газрыг ойн нөөц болгон хувиргаж, ойн нөөцийн менежментийн төлөвлөгөөг гаргаж, мод унагаах, зам тавихыг эсэргүүцэж хоригложээ. Газар нь бүхэлдээ Амазонын унаган омгуудын дархан газар гэж зарлагдсан байна. Ингээд энэ газрыг ирээдүй хойч үеийнхэндээ хамгаалан үлдээж байна. Амазонын хүмүүс ирсэн зочдод үзэсгэлэнт ойгоо үзүүлэхийн ялдамд ой мод болон өөрсдийнхөө соёлыг хамгаалан ойд амьдардаг бусад хүмүүст орон гэр, амьдралаа хамгаалахад нь тусалж байна.

Ойн нөөц

Ойн нөөцийн цэцэрлэг байгуулах нь засгийн газар болон олон улсын байгууллагуудаас ойг хамгаалж, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэмжлэг авах нэгэн хэлбэр байдаг юм. Гэхдээ засгийн газрууд болон ой хамгаалах бүлгийнхэн ойг нөөцлөнө гэдэг нь хүмүүсийг ойгоос хол байлгахыг хэлж байгаа хэмээн ойлгодог. Олон тохиолдолд энэ бол буруу юм. Ойд амьдардаг хүмүүс ойг яаж ашиглах, яаж хамгаалахаа мэддэг. Ойд байж, ойн цэцэрлэг болон нөөцийг хамгаалахдаа орон нутгийн хүмүүс ямар ч засгийн газар, байгаль орчны бүлгүүдээс илүү байж чаддаг.



Зарим орон нутгийн иргэд засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа, хороотой гэрээ хийж ойн нөөц рүү хэрхэн нэвтрэх, ойн нөөцийг хэрхэн менежмент хийх талаар тохиролцдог. Үүнийг хамтын менежментийн схем гэдэг. Хамтын менежментийн нөхөрлөл хүмүүсийг уламжлалт замаараа явж уламжлалт аргаар ойн нөөцийг ашиглахыг зөвшөөрдөг. Ойн нөөцийг удирддаг орон нутгийнхан бусад нутгийн иргэдэд ойг хамгаалах талаар сургалт явуулж зөвлөгөө өгдөг.

Ойн аж ахуй хүн ба модыг тэтгэдэг

Бразилийн Амазон дахь ширэнгэ ойд мод бэлтгэх компани, үхрийн аж ахуй болон мод огтлох, ой модонд тариалан тарих, каучук олборлох, гар урлал эрхлэх хүмүүсийн хооронд байнга зөрчил гарч байдаг. Маш их хэмжээний ширэнгэ ойг устгасны дараа ажилчид болон нутгийн унаган иргэд тэмцэл өрнүүлж, засгийн газрыг нээлттэй нөөц газар байгуулахыг ятгаж чаджээ.

Нээлттэй нөөц газар гэдэг нь ой сүйтгэхийг хориглосон боловч ойгоос бага хэмжээгээр хэрэглэхийг зөвшөөрдөг нөөц юм. Харамсалтай нь ойд насаараа амьдарсан хүмүүс хүртэл нээлттэй нөөц газрын ойгоос баялаг авч хэрэглэх зөвшөөрөл авч чадаагүй юм. Хүмүүс ойн төлөө үнэнчээр зүтгэж тэмцсэн боловч ойгоо хамгаалсныхаа үр дүнд өөрсдийн гэсэн амьжиргаагаа алджээ.

Тапагосын орон нутгийн ойн нөөцийн орчим амьдарч байгаа хүмүүс ойд тариалан тарьж, ан агнаж, ойн бүтээгдэхүүнээр сав суулга, завь болон бусад гар урлалын зүйлсийг хийж амьдардаг уламжлалтай. Бас тэд эмийн ургамал, багаж, түлш, цахилгаан болон бусад зүйлсийг худалдан авахын тулд мөнгө олох хэрэгтэй байдаг. Бага зэрэг санхүүгийн туслалцаатайгаар тэд Кабоклогийн засварын газар гэдэг нэртэй мужааны газрыг байгуулж, үүнийгээ Кабоклогийн унаган хүмүүс Африк болон европын иргэдийн нэрээр нэрлэжээ.

Хүмүүс ойг тайрч газар тариалангийн талбай гаргаж авахдаа унагаасан моднуудыг ашиглан өөр нэмж мод тайрахгүйгээр тэд тавилга ширээ сандал хийж орон нутгийн зах зээл болон Бразил даяар худалдаж эхэлжээ. Энэ бүтээгдэхүүнээс олсон орлого нь тэднийг нэмж өөр тавилгууд хийж мөнгө олох хүсэл сонирхлыг төрүүлжээ. Гэвч тэд ойн тооллого хийж ойг тогтвортой ашиглах төлөвлөгөөгөөр батлагдаагүй л бол нэмж мод тайрах эрхгүй болгосон байна. Байгаль орчны яамнаас баталдаг энэ зөвшөөрлийн шаардлагыг хангахын тулд орон нутгийн иргэд өөрсдийн ой модонд тооллого хийж эхэлжээ. Тэд ойд яг хэдэн мод байна. Түүнээс хэд нь шинэ, хэд нь шинээр гарч ирснийг дахин тоолжээ. Засгийн газрынхан уншиж бичиж чаддаггүй тосгоныхныг ийм тооллого хийсэн гэдэгт итгэхгүй байв. Гэвч тосгоныхон жинхэнэ нарийн мэргэжлийн экспертүүд байлаа. Тэд байгаль орчны эрдэмтдийг жил бүр дагуулж яван тэдэнд ургамал амьтны тухай заадаг хүмүүс байв. Харин эрдэмтэн судлаачид тэдний ачийг хариулж модыг яаж тоолох, модыг яаж энгийн шугам бариад хэмжихийг, мод жилд ямар хэмжээтэй ургаж байгааг яаж хэмжихийг зааж өгчээ.

Тосгоныхон жижиг мөртлөө өндөр үнэ хүрдэг тансаг хэрэглээний бүтээгдэхүүн хийе гэж шийдвэр гаргасан байна. Жишээлбэл, гутлын ширээ, жижиг сандал зэргийг хийхэд жилдээ бага мод орно гэдгийг тэд тооцоолжээ. Ингээд тэд жилдээ тайрах модныхоо тоог баглуулахаар яаманд явуулсан байна. Байгаль орчны яам Кабокло засварын газрынхны явуулсан төлөвлөгөөг баталж, тэдэнд ойн нөөцийг бууруулахгүйгээр орлогоо олох эрхийг нь өгчээ. Кабокло засварын газрынхан эрдэмтэд, эдийн засагчид, хөгжлийн агентлагийн ажилтнуудын олон жилийн турш тэмцээд үр дүнд хүрч чадаагүй зүйлсийг хийж чадсан байна. Ийнхүү ойг ашиглан ашиг олохын хажуугаар ойг тогтвортой нөөцлөн хадгалах менежментийн төлөвлөгөөг тэд хийж чаджээ.



Ойжуулалт

Хэзээ ч цэвэрлэгдэж байгаагүй буюу ихэд гэмтсэн хөгшин ой мод улам л ховордож байна. Эртний хуучин ой алга болсны дараа тэр дахин хэзээ ч урьдынх шигээ амьтан, ургамлын ертөнцөөр баялаг болохгүй. Харин шинээр хийсэн хоёр дахь ой, эртний ойд байсан зарим биологийн төрөл зүйлийг ургуулж арчилж чадах юм бол эртний ойтойгоо нилээд ойролцоо баялаг ой болно. Хүмүүсийн арчилж ургуулсан ой нь орон нутгийнхныг хэрэгтэй олон нөөцөөр хангаж чадна.

Эрүүл ойг ургуулахад маш удаан хугацаа шаардагддаг. Гэхдээ өнөөдөр энэ ажлыг эхлүүлэх нь чухал. Газрын элэгдлийг хянаж багасгах үндсэн мод тарих, орон нутагт тохиромжтой мод тарих зэргээр та сайн ой тарьж чадна. Ойд үндсэн мод тарихдаа түүнийг ойд ямар дэс дараа, нягтралтай байгааг тооцож даган мөрдөх нь эрүүл ой гаргаж авахад тусална.

Мод тарих нь дандаа хэрэгтэй юу?

Орон нутгийн ойжуулалтын төслийг эхлэхийн өмнө энэ төсөл нь таны орон нутгийн иргэд болон байгаль орчны хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу гэдгийг шалга. Зарим моднууд үр тариатай өрсөлдөж, газар усны төлөө тэмцэлдэнэ. Заримдаа цаг агаарын ширүүн нөхцөлд залуу модыг арчлахад хэтэрхий их ажил орно. Модыг амьдарч чадахгүй газарт тарьж ургуулах нь үр дүнгүй ажил болдог бөгөөд үхсэн модны тоог л нэмэгдүүлдэг.

Хэрэв таны орон нутгийн иргэд ойн бүтээгдэхүүнээр амьдардаг бол гоожин болон жимс зэргээр ашиглагдаж болох модыг тарьж ойг нөхөн сэргээх хэрэгтэй. Хэрэв таны орон нутгийнхан ан агнуураар амьдардаг бол хөрс, агаар, ус, амьтныг хамгаалах замаар мөн ойг байгалийнхаа жамаар сэргэхэд нь илүү анхаарах хэрэгтэй.

Ой бүх газарт ургаж чаддаггүй. Байгалиас тогтсон цөл, тал газар болон хуурай газруудад мод цөөхөн ургана. Хэрэв ийм газруудад их хэмжээний мод тарихыг оролдох юм бол орон нутгийн өвс ургамал, амьтны аймгуудын тэнцвэрийг алдагдуулдаг. Гэхдээ зэрлэг ан амьтны амьдралд нөлөөлөхгүй. Хот суурин газар болон замын дагуу, үйлдвэрийн газрын ойролцоо, сургууль нийтийн газар мод тарих нь орчны эрүүл мэндийг сайжруулж орон нутагт сайнаар нөлөөлдөг.

Газрыг хэн өмчилж байна? Хууль ямар байна вэ?

Хэрэв та тодорхой газрыг ойжуулахыг хүсч байгаа бол энэ ойгоо ургасных нь дараа ашиглах эрхээ олж ав. Ой мод тарихын өмнө тухайн газрыг хэн өмчилж байна? Мод тарих газрын эрхийг хэн олгож байна гэдгийг мэдэж авах нь дараа нь асуудал зөрчил гаргахаас хамгаалдаг. Өнөөдөр хэнд ч ашиггүй хоосон тарчиг байсан газар ой мод тарьсны дараа үржил шимтэй ашигтай газар болдог. Бас зарим газарт хүмүүсийг зарим төрлийн модыг тайрч болохгүй гэсэн хууль гаргадаг. Ингэснээр өөрийнхөө тарьсан модыг эргэж ашиглаж болохгүй болох ч магадлалтай. Таны амьдардаг газарт тийм хууль байгаа эсэхийг шалга.

Янз бүрийн моднууд янз бүрийн хэрэгцээг хангаж байдаг

Ямар мод тарихыг шийдэхийн өмнө орон нутгийн иргэдэд ямар мод хэрэгтэй байгааг судла.

